САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 10 өдөр Дугаар 513 Улаанбаатар хот

"Мая Койн" ХХК-ийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхээс татгалзах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6, 10.9.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам"-ын 5.9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Мая Койн" ХХК-ийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхээс татгалзсугай.

2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлтийг тус Хороонд дахин гаргах боломжтой болохыг "Мая Койн" ХХК (С.Төрмөнх)-д мэдэгдсүгэй.

3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхээс татгалзсантай холбогдуулан виртуал хөрөнгийн үйлчилгээг зогсоож, харилцагчдын мөнгөн хөрөнгө болон виртуал хөрөнгийг тэдгээрийн хувийн дансанд шилжүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг "Мая Койн" ХХК (С.Төрмөнх)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН